

БАТЛАВ  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

П.САЙНЗОРИГ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг  
дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн  
хэрэгжилтийг хангах зөвлөх үйлчилгээний  
ажлын даалгавар

# **“БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР**

**Зөвлөх үйлчилгээний нэр:** “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ

**Гэрээний төрөл:** Хуулийн этгээд

**Хэрэгжүүлэх байгууллага:** Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн

**Даалгаврын хугацаа:** 2 сар

## **1. ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны Үндэсний хөтөлбөр батлах тухай 50 дугаар тогтоолоор “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд энэхүү хөтөлбөр нь иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 2018-2023 онд хэрэгжүүлсэн.

Энэхүү хөтөлбөрийн 7.4-т “Хөтөлбөрийн 1, 2 дугаар үе шат хэрэгжиж дуусах хугацаанаас 6 сарын өмнө үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ хийлгэж, тайланг Үндэсний зөвлөлөөр хэлэлцэн үр дүнг Засгийн газарт танилцуулна” гэсний дагуу хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэхээр энэхүү ажлын даалгаврыг боловсруулсан болно.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх замаар хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлж, хөтөлбөрийг цаашид илүү урт хугацаанд үр дүнтэй, тогтвортой хэрэгжүүлэх шаардлага үүсч байна.

Иймд “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний тендерийг зарлаж байна.

## **2. АЖЛЫН ЗОРИЛГО**

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2018-2023 оны хэрэгжилтэд үр дүнд суурилсан хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, санал, дүгнэлт боловсруулах.

## **3. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ нь дараах хүрээг хамарна. Үүнд:

- Хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн нэгдсэн тайлан /2018, 2019, 2020, 2021, 2022, 2023/-д дүн шинжилгээ хийх;
- Зорилтот бүлгийг хамруулан социологийн судалгаа хийж санал, дүгнэлт, зөвлөмж өгөх;
- Биет ба биет бус эрх зүйн хөтчийг бий болгосон тогтолцоо /Эрх зүйн хөтөч, Эрх зүйн хөтчийн булан; e-khutuch.mn, хууль зүйн зөвлөгөө мэдээллийн 1800-1202 тусгай дугаарын үйлчилгээ, “Эрх зүйн хөтөч” пейж хуудас г.м/-г бий болгож бэхжүүлсэн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтын агуулга, хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн болон иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хийгдсэн контент /гарын авлага, шторк, нугалбар хуудас, цахим пост г.м/-д үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажил үйлчилгээний үр нөлөө, хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Хөндлөнгийн үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг цаашид илүү үр нөлөөтэй болгох чиглэлээр тодорхой санал, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах зэрэг болно.

#### **4. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Шаардлагатай тохиолдолд аливаа асуудлаар захиалагч байгууллагын удирдлагатай харилцана. Ажлын ерөнхий зорилго болон хүрээг өөрчлөхгүйгээр харилцан зөвшилцсөний үндсэн дээр энэхүү ажлын удирдамжид өөрчлөлт оруулж болно.

#### **5. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээлэл, өгөгдлийг захиалагчаас болон бусад эх үүсвэрээс цуглуулах ажлыг хийнэ. Иргэдийн эрх зүйн боловсрол, мэдлэгт зориулсан тусгай контент (гарын авлага, аудио, видео контент гэх мэт)-ын агуулга, нийтэд хүргэж буй арга хэлбэр зэрэг нь үр дүнтэй байгаа эсэхэд судалгаа, дүгнэлт хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, зөвлөмж бүхий хөндлөнгийн үнэлгээний тайланг хийж гүйцэтгэнэ.

#### **6. ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Зөвлөх үйлчилгээний багт дараах шаардлага тавигдана. Үүнд:

1. Зөвлөх үйлчилгээний баг нь 5-аас доошгүй тооны гишүүдтэй байна.
2. Иргэдийн эрх зүйн боловсрол болон Хууль зүйн судалгааны чиглэлээр ажиллаж байсан, 2-оос доошгүй хуульчтай байх /Дипломын хуулбар, хуульчийн гэрчилгээ, намтар г.м баримтуудын хуулбар/;
3. Багийн ахлагч нь доктор зэрэгтэй байх /Хууль зүй, эдийн засаг, социологийн аль нэг салбар/;

4. Багийн гишүүд нь судалгааны тогтсон арга зүй, арга барилтай байх, хөндлөнгийн үнэлгээ, судалгаа хийж байсан туршлагатай байх /баримтаар нотлох/;
5. Анкетын судалгаа авахад шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;
6. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ, судалгаа хийж байсан туршлагатай бол давуу тал болно.

## **7. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН**

"Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн /2018-2023/ хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, дүгнэлт, зөвлөмж бүхий судалгааны тайланг боловсруулж захиалагчид ирүүлсэн байна.

## **8. ХЭРЭГЖИХ ХУГАЦАА**

2 сарын хугацаанд зөвлөх үйлчилгээг гүйцэтгэнэ.

№	Хэрэгжих ажил	Хугацаа
1	Хөндлөнгийн үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө, санал асуулгын загвар гаргах, судалгаа хийх, эхлэлийн тайлан гаргах	Хуанлийн 10 хоног
2	Хөндлөнгийн үнэлгээний явцын тайлан, судалгаа	Хуанлийн 30 хоног
3	Хөндлөнгийн үнэлгээний эцсийн тайлан, танилцуулга	Хуанлийн 20 хоног

## **9. ТӨСӨВТ ӨРТӨГ**

Төсөвт өртөг 40.000.000 /дөчин сая/ төгрөг байх бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу аливаа татвар, шимтгэл энэ үнийн дунд багтсан болно. Гэрээнд 2 тал харилцан гарын үсэг зурснаас ажлын 7 хоногийн дотор гэрээний үнийн дүнгийн 30 хувийг, явцын тайлан, судалгааг хүлээн авсны дараа 40 хувийг, эцсийн тайланг хүлээн авснаас хойш хуанлийн 7 хоногийн дотор үлдэх 30 хувийн төлбөрийг шилжүүлнэ.